



СЭЛЭНГЭ АЙМАГ
ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 1/85

Жаргалант

Бог малд үзлэг ангилалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а" Малын генетик нөөцийн тухай хуулийн 18-р дугаар зүйлийн 18.3, 18.3.1, 18.3.4 дэх заалт Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/68 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны А/133 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малд, үзлэг ангилалт хийх, хээлтүүлэгч малыг ялган тэмдэглэх ээмэгжүүлэх ажлыг 2020 оны 5 дугаар сард багтаан хийж гүйцэтгэхийг хөдөө, аж ахуйн тасгийн мэргэжилтэн /Х.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.

2. Малд үзлэг ангилалт хийх ажилд сумын малчин, мал бүхий иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулахыг Бумбат 1 дүгээр багийн Засаг дарга Ц.Дарханбаатар, Моностой 2 дугаар багийн Засаг дарга Д.Удвалцэцэг нарт тус тус даалгасугай.

3. Дээрх үзлэг ангилалтыг зохион байгуулж 2020 оны 07 дугаар сарын 01-ний дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн программд оруулж баталгаажуулахыг хөдөө, аж ахуйн тасгийн мэргэжилтэн /Х.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.ОТГОНДАЛАЙ